



### Цаг үе, үйл явдал

## БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР “ОЮУТАН ЦЭРЭГ”-ҮҮДИЙН ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТЫН ЯВЦТАЙ ТАНИЛЦАВ



Цар тахлын улмаас сүүлийн хоёр жил тасалдаад байсан “Оюутан цэрэг” сургалт дөрөвдүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 52 их, дээд сургуулийн 452 оюутан цэргийн эрдэмд суралцаж байна. Эдгээр оюутнууд нь энэхүү сургалтад хамрагдахын тулд голч дүн 3.4 болон түүнээс дээш байж, эрүүл мэндийн үзлэг, бие бялдрын шалгуур давсан бөгөөд эхний шатандаа “Цэргийн ерөнхий бэлтгэл” онолын сургалтыг МУИС, ШУТИС, ХҮИС, МУБИС-дад тус тус танхимаар хоёр сарын хугацаанд хамрагдсан юм. Үргэлжүүлэн ҮБХИС-ийн Шар хад дахь Сургалтын төвд “Цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалт”-д хамрагдаж, цэргийн албанд дасгах, мэргэжлийн бэлтгэл, цэргийн

мэргэжил олгох гэсэн гурван үе шаттайгаар суралцаж байна.

Тэгвэл оюутан цэргүүдийн сургалтын явц, ахуй орчин, цэргийн албанд хэрхэн дасан зохицож буйтай Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр тэргүүтэй албаныхан энэ сарын 20-ны өдөр танилцсан юм. Сайдыг дагалдаж Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан болон бусад их, дээд сургуулиудын захирал, албаны бусад хүмүүс ажилласан

юм.

“Цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалт”-д хамрагдаж байгаа оюутнууд дөрвөн бүлэгт хуваагдан дадлага, сургалтад хамрагдаж байна. Сургалтыг эрчимжүүлсэн, вакуумжуулсан тусгай хөтөлбөрөөр өдөрт 10 цагийн багц хичээлээр явуулж байгаа бөгөөд энэ хүрээнд цэргийн дүрэм, жагсаалын бэлтгэл, тактик, галын бэлтгэл, цэргийн байр зүй, зенит, артиллерийн бэлтгэл, амьд гарах арга ухаан, анхны тусламж зэрэг 12 хичээлийг нийт 560 цагийн багтаамжтайгаар явуулж байгаа юм. Эдгээр нь цэргүүдэд бие бялдар, сэтгэл зүйн тэсвэр хатуужил олгох, байлдаанд байлдагчийн үүргийг биелүүлэх, тасаг тоотын жигдрэлтийг хангах, хүн нэг бүрт цэргийн бага мэргэжил эзэмшүүлэхэд тус сургалт чиглэж байна.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр тэргүүтэй албаныхныг хээрийн байрлалд ажиллах үеэр оюутан цэргүүд хэдийнээ цэргийн албандаа дасаж мэргэжлийн бэлтгэл, цэргийн мэргэжил олгох сургалтууддаа амжилттай хамрагдахын зэрэгцээ сургалтын хөтөлбөрийн дагуу байлдааны буудлагатай хээрийн сургууль, амьд гарах арга ухаан, холбоо, тагнуул, эрүүл мэнд гэсэн тус тусын цэгүүдэд сургалтууддаа хамрагдаж байв.

Албаныхан сургалтын цэгүүдтэй танилцсаны дараа нийт бие бүрэлдэхүүнтэй уулзаж, ярилцсан юм. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр “Хоёр сар гаруйн өмнө танхимд хичээллэж байхад нь уулзаж байсан залуу өнөөдөр танигдахгүй болж. Та бүхэн хөрслөг бор, булчин шөрмөс нь зангирсан хэдийнээ эр цэргүүд болсон байна. Энэ бол зөвхөн харагдах байдал юм” хэмээгээд “Монгол Улс бол Үндсэн хуульд заасны дагуу улс орны аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг

төрийн үүрэг гэж үздэг. Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үүрэгтэй байдаг. Манай улсад цэргийн алба хаах олон хэлбэр бий. Хугацаат цэргийн алба, оюутан цэргийн алба, цэргийн жинхэнэ алба гэх мэт. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчин бол Монгол Улсын тусгаар тогтнол аюулгүй байдлыг гаднын зэвсэгт халдлага түрэмгийллээс хамгаалах үүргийг хүлээдэг. Оюутан цэргийн сургалт 2014 оноос хэрэгжиж байна.

Цар тахлын улмаас оюутан цэрэг хөтөлбөр хоёр жилийн хугацаанд завсарлалаа. Энэ хугацаанд нийгэм, залуусын хүлээлт их байсан.

Хэдийгээр 12 сарын хугацаанд цэргийн алба хаах хуультай боловч оюутан залуусаас шигшигдэж ирсэн залуус та бүхэн богино хугацааны эрчимжсэн сургалтад хамрагдан ачаалал дааж, цэргийн мэргэжил эзэмшсэнээ байгаа байдлаараа, хийж буй үйлдлээрээ харуулж байгаад салбарын сайдын хувьд баяртай байна.

Мөн та бүхэн ирээдүйд өөртөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд, мөн иргэний үүргээ үнэнчээр биелүүлэхээр энэхүү сургалтад хамрагдаж байгаа. Тус хөтөлбөрт хамрагдсанаар эх оронч үзэлтэй, нийгэм, гэр бүлийн хандлага, хариуцлага сайжирч, хууль журмыг ойлгож авсан гэдэгт итгэлтэй байна. Улс орны ирээдүй болсон залуус та бүхэн эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн зэрэгцээ цэргийн нөхөрлөлийг мэдэрч, алба амжилттай хаахыг хүсье” гэв.

Сонирхуулахад 2014 оноос хойш 7 удаагийн “Оюутан цэрэг” сургалтад 5000 гаруй оюутан хамрагджээ.



### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
26	12

#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
30	23

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.165.00	3.175.0
EUR	3.175.0	3.250.0
CNY	470.00	475.00
RUB	51.00	52.00
JPY	22.60	23.40
KRW	2.38	2.42

### ЗУРХАЙ



2022.07.21 /ПҮРЭВ ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 24

**ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ  
САРЫН НЭГ ЦАГААН  
МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТАХИА  
ӨДӨР**

#### Үс засуулбал:

Өвчин ирнэ  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
05.13-20.44  
БАРИЛДЛАГА:

Үхэх

Шүтэн барилдлага:

Мунхрахуй  
Суудал: Уул

Энэ өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Мод суулгах, нарийн чанд зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогосод баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

#### Тохиолдол

Нийт: 567,857,190

#### Эдгэрсэн

Нийт: 539,000,442

#### Нас барсан

Нийт: 6,387,812

Цахим шууданд

# “АРАВТ” УРАЛДААН МОНГОЛ УЛСАД ХОЁР ДАХЬ ЖИЛДЭЭ ...



“Олон улсын цэргийн наадам”-ын хүрээнд “Аравт” олон улсын морин цэргийн уралдаан Монгол Улсад ирэх сарын 13-18-ны өдрүүдэд зохион байгуулагдах гэж байна. Энэхүү уралдаан нь бэлтгэлийн, алсын зайны морин маршийн, богино зайны холимог буухиа, төгсгөлийн буюу тэмцээнийг дүгнэх гэсэн дөрвөн үе шаттай явагдана. Нэгдүгээр шат нь тэмцээндээ бэлтгэх үе шат бөгөөд оролцогч орны баг тамирчдыг хүлээн авч байрлуулах, аюулгүй ажиллагааны заавар танилцуулах, энэ чиглэлийн сургалтууд явуулах, уралдааны бэлтгэлийг

хангуулах, морьтой дадлага сургалт хийх, уралдааны маршрутыг баг тамирчдад танилцуулах юм. Хоёрдугаар шатанд алсын зайны морин марш зохион байгуулагдана. Энэ шатанд уралдаанаар оролцогч орны цэргийн алба хаагчид уул, ой мод, гол ус, элс, бартаа саад бүхий 130 км замыг маршрутын дагуу туулна. Гэхдээ зүгээр туулаад өнгөрөхгүй, замдаа цэрэг хүний гүйцэтгэх ёстой дөрвөн даалгаварыг гүйцэтгэнэ. Үүнд усан болон минжүүлсэн талбайг туулах, морь бугуйлдах, уналгад бэлтгэх даалгавар, бартаа саад бүхий газарт хоноглох даалгавар, эцэст нь шархтанд эмнэлгийн

анхан шатны тусламж үзүүлэх, шархтан, сум галт хэрэглэлийг хөнөөлийн голомтоос татан гаргах даалгавар зэрэг багтана. Усан саадаар урсгал ширүүн гол туулж, минийн саадыг давах бол морь сэлгэх даалгавраар адуун сүргээс морь бугуйлдаж уналгад бэлдэх юм. Харин гуравдугаар шат болох ойрын зайны холимог буухиагаар оролцогч орны баг тамирчид явганаар болон морьтойгоор маршрутын дагуу байрлах цэгүүдэд өгөгдсөн гранат шидэх, саадын зурвас туулах, буудлагын дасгал гүйцэтгэх, тактикийн ажиллагаа, морины давхилт дунд гранат

шидэх зэрэг даалгавруудыг гүйцэтгэн барианд орох юм. Төгсгөлд нь тэмцээний дүнг нэгтгэж, уралдаанд амжилт үзүүлсэн баг тамирчдад шагнал гардуулах ёслол болно. Ташрамд онцлоход, уралдааны бэлтгэл явцад Монгол Улсын зан заншил, түүх, соёл уламжлалыг сурталчлах, цэргийн алба хаагчдын нөхөрлөлийг бататгах хүрээнд бэсрэг наадам, соёл урлаг болон спортын өдөрлөгүүд, “Адуучин” тэмцээн зэрэг олон арга хэмжээг шат дараатай зохион байгуулахаар “Аравт”-ын арын албаныхан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.




## ГУРВАН АНГИЙН ХУГАЦААТ ЦЭРГҮҮД ОРОЙН ТООЛЛОГО ЯВУУЛЛАА

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, Зэвсэгт хүчний 120, 256 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчид нөхөрсөг уулзалт зохион байгуулж, нэгэн өдрийг хамтдаа өнгөрөөв. Нэгтгэл, ангийн хугацаат албаны дайчид хамтдаа Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн цэргийн байр, ангийн штаб, цэргийн гал тогоо, “Алдрын танхим”-аар зочилж, тус ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа Д.Сүхбат Зэвсэгт хүчний ууган ангийн нэг болох танкийн тусгай хорооныхны

дайны жилүүдэд болон энхийн цагт байгуулсан гавьяаг танилцуулж, монгол цэргийн ялалт, тэмцлийн түүхээр аялуулав. Үүний дараа дайчид өөрийн нэгтгэл, ангийнхаа онцлогийн талаар бие биедээ ярьж өгч, авьяаслаг залуус нь ая дууны мэндчилгээгээр нэгэндээ бэлэг барилаа. Дэд түрүүч Ш.Эрдэнэсайхан (256), дэд түрүүч Б.Ням-Очир (016), байлдагч Г.Золбоо (120) нар Зэвсэгт хүчний аварга шалгаруулах “Марш-тусгай бэлтгэл”-ийн цогцолбор тэмцээнээр тааралдаж,

танилцаж байснаа хуучилж, ижилссэн хувцсаараа ч тэр, эх орондоо өргөсөн тангаргаараа ч тэр нэг л зорилготой эх орны хөвгүүд гэдгээрээ бахархаж буйгаа тодотгон ярилаа. Хамгийн сонирхолтой нь энэхүү нөхөрсөг уулзалтын үеэр хоёр өөр ангид хуваарилагдсан үеэлүүд ч тааралдаж, хамтдаа дурсгалын зураг татуулж, ар гэрийнхэндээ захидлаар илгээлгэв. Нөхөрсөг уулзалтын төгсгөлд гурван нэгтгэл, ангийн дайчид нэгдсэн оройн тооллого явууллаа.



# НАМСРАЙН СҮХБААТАРЫН НЭРЭМЖИТ ГАР БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН БОЛОВ




БХИС-ын багш дэд хурандаа Сүхбаатарын нэрэмжит Нийслэлийн 53-р сургуулийн 1985-1992 оны төгсөгчдийн дундах гар бөмбөгийн тэмцээн болж өндөрлөлөө. Тэмцээний Намсрайн Сүхбаатартай хамт тоглож байсан тамирчид, гэр бүл, найз нөхөд нь оролцлоо.

Намсрайн Сүхбаатар нь Монгол улсад анх удаа Волейболын дээд лиг зохиогдоход лигийн шилдэг довтлогч болж байсан Монголыг шилдэг тамирчин багш Үндэсний шигшээ багт амжилттай тоглож олон улсад Монгол улсынхаа нэрийг мандуулж байсан сайхан түүхтэй юм.



## "ШОНХОР" ЗУСЛАНГИЙН 4,5-Р ЭЭЛЖИЙН БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА



**ЭНЭ ЭЭЛЖИЙН  
ОНЦЛОХ ОНЦГОЙ  
ҮЙЛЧИЛГЭЭ**  
Манай "Шонхор" зуслан 4-р элжиндээ YETI Educational Academy-тай хамтран 7 хоногийн Орос, Англи хэлийг сонгон судлах сургалт зохион байгуулагдахаар боллоо.  
**БАЙГАЛИЙН  
САЙХАНД СУРАЛЦАНГАА  
ХӨГЖЬЕ.**  
Манай үндсэн төлбөр: 350000  
Байршил: Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон  
Ээлжийн хугацаа: 4-р ээлж: 2022.07.25-08.01  
5-р ээлж: 2022.08.01  
Хүүхдийн тоо хязгаартай  
Үндсэн 6 чиглэлийн 30 гаруй хөгжлийн хөтөлбөрөөр хүүхэд багачууд, амрагчдад үйлчилж, төвлөрсөн, өртөөчилсөн, буухиа болон сонголтын төв хэлбэрээр үйл

ажиллагааг хэрэгжүүлнэ. Манай хөтөлбөрүүдээс дурдвал: Цэргийн анхан шатны мэдлэг цогцолбор төв Бид чадна цогцолбор төв Галын бэлтгэл цогцолбор төв Үндэсний өв соёл, тоглоом наадгайн өдөрлөг Movie time алын наадам Оройн диско Улаг, Спортын өдөрлөг Бүчний дайн стратегийн тоглоом Хээрийн аялал Хаадын эрэлд гэх мэт маш олон сонирхолтой үйл ажиллагаа амрагч хүүхдүүдийг маань хүлээж байна. Холбогдох утас: 94547009, 99741079, 99239347

